



2020 оны 11 дүгээр сарын 18
№43 /1145/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
Хууль**

**Зээлийн хэлэлцээр соёрхон
батлах тухай**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Түр хороог байгуулж,
бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Нийгмийн халамжийн сангаас
олгох протез, ортопедийн болон
тусгай хэрэгслийн жагсаалт,
жишиг үнийг шинэчлэн
батлах тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

467. Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай 2281

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

468. Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай Дугаар 31 2282

469. Тогтоолын төсөл буцаах тухай Дугаар 33 2284

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

470. Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг шинэчлэн батлах тухай Дугаар 193 2284

471. Журам шинэчлэн батлах тухай Дугаар 194 2288

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

472. Монгол Улс болон Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын зээлийн хэлэлцээр 2293

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 10 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс болон Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хооронд 2020 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр байгуулсан “Ковид-19 цар тахлын эсрэг шуурхай хариу арга хэмжээ авах хөтөлбөр”-ийн



Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 10 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 31

Улаанбаатар
хот

Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэг, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 6.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсугай:

Түр хорооны дарга:

Б.Баттөмөр

Улсын Их Хурлын гишүүн,
Аюулгүй байдал, гадаад
бодлогын байнгын хорооны
дарга

Түр хорооны гишүүд:

Х.Болорчулуун

Улсын Их Хурлын гишүүн,
Байгаль орчин, хүнс, хөдөө аж
ахуйн байнгын хорооны дарга

Ж.Мөнхбат

Улсын Их Хурлын гишүүн,
Боловсрол, соёл, шинжлэх
ухаан, спортын байнгын
хорооны дарга

Б.Бат-Эрдэнэ	Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга
Н.Учрал	Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга
М.Оюунчимэг	Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга
Л.Энх-Амгалан	Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга
Б.Жавхлан	Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга
Б.Чойжилсүрэн	Улсын Их Хурлын гишүүн, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга
С.Бямбацогт	Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга
Ж.Ганбаатар	Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга
Б.Бейсен	Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн төлөөлөл
С.Ганбаатар	Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь “Та бидний эвсэл”-ийн төлөөлөл
Т.Доржханд	Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь “Зөв хүн электорат эвсэл”-ийн төлөөлөл
Н.Алтанхуяг	Улсын Их Хурлын гишүүн, бие даагч



2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Түр хороо байгуулах тухай” 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 49 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 11 дүгээр
сарын 05-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 5 гишүүнээс 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Их Хурал 30 жил” ойн хүндэт медаль бий болгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 193

Улаанбаатар
хот

Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг шинэчлэн батлах тухай

Ахмад настны тухай хуулийн 8.1.1, 13.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг шинэчлэн баталсантай холбоотойгоор нэмж шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт даалгасугай.

3.Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээний хүрээнд зарим нэр, төрлийн протезийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлттэй үнээр хийж байгаа улсын эмнэлгүүдээс гадна хувийн хэвшлийн эмнэлгүүдийн тоог нэмэгдүүлж, иргэдэд тусламж үйлчилгээ хүртээмжтэй, шуурхай үзүүлэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ тогтоох тухай” Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 316 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ тогтоолыг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЧИНЗОРИГ

Засгийн газрын 2020 оны
193 дугаар тогтоолын хавсралт

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ОЛГОХ ПРОТЕЗ, ОРТОПЕДИЙН БОЛОН
ТУСГАЙ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ, ЖИШИГ ҮНЭ**

№	Хэрэгслийн нэр, төрөл	Жишиг үнэ (төгрөгөөр)	Хамрагдах бүлэг
Дотоодын үйлдвэрт захиалгаар үйлдвэрлэх протез, ортопед, тусгай хэрэгсэл			
Протезийн төрлүүд			Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхэд, ахмад настан
1.	Шилбэний протез	620.000	



2.	Дунд чөмөгний протез		1.000.000
3.	Сүүж, түнхний протез		1.200.000
4.	Тавхайн урд хэсгийн протез		400.000
5.	Хошуувч, башмачок		120.000
6.	Өвдөгний тулгууртай протез		900.000
7.	Мөр, бугалганы протез		800.000
8.	Шууны протез		500.000
9.	Сарвууны протез		250.000
10.	Гарын хурууны протез		105.000
11.	Шилэн нүд		50.000-120.000
Ортопедийн хэрэгслүүд			
12.	Согог засах өвлийн гутал		150.000-180.000
13.	Согог засах хавар, намрын гутал		150.000-220.000
14.	Согог засах зуны гутал		140.000-150.000
15.	Өндөрлөгтэй улавч	10-22 хэмжээ хүртэлх	25.000
		36-42 ба түүнээс дээш	50.000
16.	Пронатор, супинатор улавч	10-22 хэмжээ хүртэлх	25.000
		36-42 хэмжээ ба түүнээс дээш	30.000
17.	Нурууны ширэн хамгаалалт	бүсэлхий нурууны	150.000
		сээр, бүсэлхий, ууц нурууны	200.000
18.	Нурууны даавуун хамгаалалт	бүсэлхий нурууны	60.000
		сээр, бүсэлхий, ууц нурууны	80.000
19.	Нурууны хуванцар хамгаалалт	бүсэлхий нурууны	200.000
		сээр, бүсэлхий, ууц нурууны	250.000
20.	Хөлийн чиг бүхий аппарат (урт)	шагайн үетэй	350.000
		шагайн үегүй	300.000
21.	Хөлийн чиг бүхий аппарат (богино)	насанд хүрэгсдийн	220.000
		хүүхдийн	180.000
22.	Гарын чиг	бугуйн чиг	50.000
		шууны чиг	70.000
		бугалганы чиг	150.000
23.	Шагайн чиг	үегүй	90.000
		үетэй	120.000
24.	Суга өргөгч чиг		100.000



25.	Ивэрхийн даруулга	пружинтэй	40.000	
		даавуун	70.000	
26.	Бөөрний даруулга		40.000	
27.	Павликийн дөрөөвч		50.000	
28.	Хүзүүвч		60.000	
29.	Хүзүүний бэхэлгээ		50.000	
Тусгай хэрэгслүүд				
30.	Төмөр суга таяг (хос)		48.000	
31.	Тохойн тулгууртай таяг (хос)		48.000	
32.	Зогсоогч (хүүхдийн)		190.000	
33.	Тавцантай ширээ (хүүхдийн)		190.000	
Гэрээт байгууллага олгох тусгай хэрэгсэл				
34.	Тэргэнцэр (насанд хүрэгсдийн)		250.000	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн
35.	Хөтөвч, суултуур (насанд хүрэгсдийн)		80.000	
36.	Алхуулагч (насанд хүрэгсдийн)		60.000	
37.	Модон таяг (хос)		10.000-15.000	
38.	Гар таяг		10.000	
39.	Эмчилгээний өвдгөвч (нэг тал)		10.000-15.000	Ахмад настан
40.	Тэргэнцэр (энгийн)		340.000	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
41.	Тэргэнцэр (атгагч, ширээ, түшдэг, хэвтдэг хүзүүвчтэй)		800.000	
42.	Хүүхдийн цээживч		420.000	
43.	Эмчилгээний бөмбөг (зуйван)		80.000	
44.	Эмчилгээний бөмбөг (бөөрөнхий)		60.000	
45.	Алхуулагч (хүүхдийн)		145.000	
46.	Тамбформ (олон төрлийн хэлбэр бүхий зөөлөвч ивээс)		60.000	
47.	Гарын анчер (саажилттай хүүхдийг бие засахад суулгаж тогтоодог чиглүүлэгч)		280.000	
48.	Гар, хөлийн спилен (бугуй тэгшлэгч, эрхий салгагч)		45.000	
49.	Хөтөвч, суултуур (хүүхдийн)		25.000	
50.	Хараагүй хүний брайлийн хэрэгсэл (брайль цаас 300 ширхэг, брайль шугам, бичгийн машин, брайль тэмдэглэлийн дэвтэр)		120.000	Бүрэн хараагүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхэд
51.	Дизи тоглуулагч (хараагүй хүний ярьдаг ном унших)		620.000	
52.	Компьютерийн ярьдаг програм хангамж, нэмэгдэл төхөөрөмж		240.000	
53.	Брайль цаг		36.000	
54.	Бичиг томруулагч линзэн шил		36.000	



55.	Ярьдаг халууны шил	60.000		
56.	Ярьдаг цаг	30.000		
57.	Ярьдаг даралтын аппарат	180.000		
58.	Радио хүлээн авагч	50.000		
59.	Цагаан таяг	70.000		
60.	Мэдрэгчтэй цагаан таяг	145.000		
Тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллага хийх, олгох протез, ортопед, тусгай хэрэгсэл				
61.	Хиймэл шүд	3 хүртэлх	40.000	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн
		6 хүртэлх	80.000	
		7 ба түүнээс дээш	130.000	
62.	Харааны шил	20.000	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхэд	
63.	Контактны линз (+5,-5 болон түүнээс дээш)	120.000		
64.	Сонсголын дижитал аппарат	500.000		
65.	Насанд хүрэгсдийн Stom-ийн уут (100 ширхэг)	860.000	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн	
66.	Хүүхдийн Stom-ийн уут (100 ширхэг)	860.000	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 194

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 16.2, Ахмад настны тухай хуулийн 13.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.4, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 6.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Нийгмийн халамжид хамрагдах иргэний хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, нэмэгдэл, хөнгөлөлттэй холбоотой харилцааг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт даалгасугай.

3.Нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээллийн нэгдсэн системийн тасралтгүй хэвийн, аюулгүй байдлыг хангаж, хөгжүүлэлт хийж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (Т.Бадрахбаяр), Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв (Т.Батбилэг)-д тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЧИНЗОРИГ

Засгийн газрын 2020 оны
194 дүгээр тогтоолын хавсралт

**НИЙГМИЙН ХАЛАМЖИД ХАМРАГДАХ ИРГЭНИЙ ХҮСЭЛТИЙГ
ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай, Алдар цолтон ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль (цаашид “хууль” гэх)-д заасан нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, нэмэгдэл, хөнгөлөлт (цаашид “нийгмийн халамж” гэх)-д хамрагдах иргэн цахим хэлбэрээр хүсэлт гаргах, уг хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэхэд энэ журмыг баримтална.

1.2.Иргэн нийгмийн халамжид хамрагдах хүсэлтээ цахим хэлбэрээр гаргах боломжгүй тохиолдолд хүсэлтээ холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сум, хорооны нийгмийн ажилтанд гаргана.

**Хоёр. Иргэн цахим хэлбэрээр
хүсэлт гаргах**

2.1.Иргэн нийгмийн халамжид хамрагдах хүсэлтээ дараах цахим системийг ашиглаж гаргана:

2.1.1.нийгмийн халамжийн нэгдсэн систем буюу “www.esare.mn” цахим хуудас болон “esare” гар утасны аппликейшн (цаашид “систем” гэх);



2.1.2.төрийн үйлчилгээний цахим машин (цаашид “ТҮЦ машин” гэх).

2.2.Энэ журмын 2.1.1-т заасан системд хандан хүсэлт гаргах иргэн системийн “Бүртгүүлэх хэсэг”-т дараах мэдээллийг кирилл үсгээр бичиж, бүртгүүлнэ:

- 2.2.1.регистрийн дугаар;
- 2.2.2.эцэг/эхийн нэр;
- 2.2.3.өөрийн нэр;
- 2.2.4.цахим шуудан (имэйл)-ийн хаяг;
- 2.2.5.гар утасны дугаар.

2.3.Энэ журмын 2.2-т заасны дагуу бүртгүүлсэн иргэний цахим шуудан, эсхүл гар утсанд системд нэвтрэх “нууц үг” бүхий мэдээлэл ирнэ.

2.4.Иргэн системийн “Нэвтрэх хэсэг”-т өөрийн регистрийн дугаар болон энэ журмын 2.3-т заасан “нууц үг”-ийг оруулснаар цахим системийг ашиглан нийгмийн халамжид хамрагдах хүсэлт гаргах нөхцөл бүрдэнэ.

2.5.Иргэн системийн “Хувийн мэдээлэл хэсэг”-т дараах мэдээллийг кирилл үсгээр бичиж оруулна:

2.5.1.байнга оршин суугаа газрын хаяг;

2.5.2.Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банк дахь өөрийн төгрөгийн харилцах дансны нэр, дугаар.

2.6.Иргэн холбогдох хууль тогтоомжид заасан шалгуур, нөхцөлийг хангасан нийгмийн халамжийн төрлөөс сонгож, системээс өгөгдөх зааврын дагуу өргөдлийн маягт, бусад холбогдох баримт бичгийг цахим хэлбэрээр байршуулж, хүсэлтээ илгээнэ.

2.7.Системд байршуулах боломжгүй, нэмэлтээр шаардагдах баримт бичгийг системээс өгөгдөх зааврын дагуу цахим хэлбэрт хөрвүүлж, хавсаргана.

2.8.Иргэн энэ журмын 2.1.2-т заасны дагуу хүсэлт гаргахдаа “ТҮЦ машин”-д регистрийн дугаар, хурууны хээг бүртгүүлж, холбогдох хууль тогтоомжид заасан шалгуур, нөхцөлийг хангасан нийгмийн халамжийн төрлөөс сонгож, дэлгэц дээрх зааврын дагуу хүсэлтээ илгээнэ.

2.9.Энэ журмын 2.2, 2.5-д заасан мэдээллийн үнэн зөвийг иргэн өөрөө хариуцна.

Гурав. Иргэний цахим хүсэлтийг хянан шийдвэрлэх

3.1.Сум, хорооны нийгмийн ажилтан энэ журмын 2.1-д заасан системд хандан хүсэлт гаргасан иргэний цахим хүсэлтийг ажлын 3 хоногийн дотор хянан бүртгэж, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагад илгээнэ.

3.2.Иргэний цахим хүсэлтэд хавсаргасан баримт бичиг нь холбогдох хууль тогтоомжид заасан шалгуур, нөхцөлийг хангахгүй байгаа тохиолдолд сум, хорооны нийгмийн ажилтан тухайн иргэнээр зөрчлийг арилгуулж мэдээллийн үнэн, бодит байдлыг хангуулах арга хэмжээ авна.

3.3.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага нь энэ журмын 2.1-д заасан системд хандан хүсэлт гаргасан иргэний цахим хүсэлт болон сум, хорооны нийгмийн ажилтнаас ирүүлсэн иргэний хүсэлтийг ажлын 5 хоногийн дотор хянан баталгаажуулна.

3.4.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага иргэний цахим хэлбэрээр ирүүлсэн хүсэлтэд хавсаргасан баримт бичиг холбогдох хууль тогтоомжид заасан шалгуур, нөхцөлийг хангахгүй байгаа тохиолдолд сум, хорооны нийгмийн ажилтанд шилжүүлж, мэдээллийн үнэн, бодит байдлыг хангуулна.

3.5.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага цахим хэлбэрээр хүсэлт гарган нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамрагдсан иргэн тус бүрд цахим хувийн хэрэг үүсгэн архивлана.

Дөрөв. Нийгмийн халамж олгох

4.1.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, нэмэгдэл, хөнгөлөлтийг иргэнд цахим хэлбэрээр хүсэлт гаргасан өдрөөс эхлэн тооцож олгоно.

4.2.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага нийгмийн халамжид хамрагдах эрх үүссэн иргэний мэдээлэл бүхий жагсаалт (цаашид “жагсаалт” гэх)-ыг сар бүрийн 10, 20-ны өдрийн дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.3.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 4.2-т заасан жагсаалтыг холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийн сантай тулган баталгаажуулж, тухайн сарын батлагдсан төсвийн хуваарийн дагуу сар бүрийн 13, 23-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын



Төрийн сангийн газар (цаашид “Төрийн сангийн газар” гэх)-т цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.

4.4.Төрийн сангийн газар нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн жагсаалт болон төлбөрийн хүсэлт (ТТ1 маягт)-д үндэслэн тухайн иргэний системд бүртгэлтэй дансанд холбогдох санхүүжилтийг сар бүрийн 15, 25-ны өдрийн дотор байршуулна.

4.5.Төрийн сангийн газар нийгмийн халамжийн мөнгөн олголт хийгдсэн талаарх хаалтын жагсаалтыг сар бүрийн 30-ны өдрийн дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.6.Нийгмийн халамжид хамрагдсан иргэний системд бүртгэлтэй дансны дугаар, нэр болон бусад мэдээлэл зөрүүтэйн улмаас санхүүжилт буцаагдсан тохиолдолд системээс тухайн иргэнд мэдэгдэл хүргүүлнэ.

4.7.Иргэн мэдэгдэл хүлээн авснаас хойш хуанлийн 15 хоногийн дотор системд мэдээллээ залруулан баталгаажуулна.

4.8.Иргэн энэ журмын 4.7-д заасан хугацаанд мэдээллээ залруулаагүйн улмаас буцаагдсан саруудын мөнгөн олголтыг мэдээллэл залруулсан хугацаанаас хамаарч тухайн, эсхүл дараа сард нөхөн олгоно.

4.9.Иргэн тухайн жилийн 12 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө мэдээллээ залруулаагүй тохиолдолд мөнгөн олголтыг дараа оны төсвөөс нөхөн олгохгүй.

4.10.Энэ журмын 4.2, 4.3-т заасан мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус хариуцна.

Тав. Тайлагналт, хяналт шалгалт

5.1.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага халамжийн сангийн мэдээ, тайланг холбогдох хууль тогтоомжид заасан хугацааны дагуу гаргаж тайлагнана.

5.2.Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн нь цахим хэлбэрээр хүсэлт гаргаж, нийгмийн халамжид хамрагдах эрх үүссэн иргэний цахим хувийн хэрэг, олголтын жагсаалтад тухай бүр хяналт тавина.



5.3.Сум, хорооны нийгмийн ажилтан цахим хэлбэрээр хүсэлт гаргаж, нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамрагдсан иргэдээс түүврийн аргаар сонгож, тухайн иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, нэмэгдэл, хөнгөлөлтөө өөрөө авч байгаа эсэхэд сард нэг удаа хяналт тавина.

5.4.Энэ журмын 5.3-т заасан хяналтаар аливаа зөрчил илэрсэн тохиолдолд сум, хорооны нийгмийн ажилтан гарсан зөрчлийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

5.5.Нийгмийн халамжийн байгууллага төрийн хяналт, шалгалтын байгууллагад иргэний цахим хувийн хэргийн бүрдэл, бусад баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгуулна.

Зургаа. Бусад

6.1.Иргэн хуурамч баримт бичиг үйлдэх, худал мэдээлэх зэргээр нийгмийн халамжид хамрагдсан нь тогтоогдвол Нийгмийн халамжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэж, тэтгэвэр, тэтгэмж, тусламж, нэмэгдэл, хөнгөлөлтийн олголтыг зогсоож, нөхөн төлүүлнэ.

6.2.Нийгмийн халамжид хамрагдах иргэний баримт бичгийг буруу хянан баталгаажуулсан, хамрагдах хугацааг буруу, алдаатай тогтоосон албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ЗЭЭЛИЙН ДУГААР –Л0414А

МОНГОЛ УЛС

болон

АЗИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК

хоорондын

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

(КОВИД-19 цар тахлын эсрэг шуурхай хариу арга хэмжээ авах хөтөлбөр)

Огноо: 2020 оны 9 дүгээр сарын 8



ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

МОНГОЛ УЛС (“Зээлдэгч” гэх) болон АЗИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК (“Банк” гэх) хооронд энэхүү Хэлэлцээр (“Зээлийн хэлэлцээр” гэх)-ийг 2020 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр байгуулав. Энд:

(а) Банк Зээлийн хэлэлцээрийн Хуваарь 1-т тусгагдсан КОВИД-19 цар тахалтай холбогдуулан Зээлдэгчийн хэрэгжүүлэх тодорхой зорилго, бодлого, арга хэмжээ бүхий мөчлөг сөрсөн хөгжлийн төсвийн хөтөлбөр (“Хөтөлбөр” гэх)-ийн талаар 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хөгжлийн бодлогын захидал (“Бодлогын захидал” гэх)-ийг хүлээн авсан;

(б) Зээлдэгч нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор зээл авах хүсэлтийг Банканд гаргасан;

(в) Бодлогын санхүүжилт нь Зээлдэгчид төсвийн ерөнхий дэмжлэг хэлбэрээр олгогдох тул Хөтөлбөрийн эх үүсвэр нь Зээлдэгчийн тодорхой чиглэлийн тодорхой зардлыг санхүүжүүлэхэд зориулагдаагүй;

(г) Банк нь энэхүү зээлийн хэлэлцээрт заасан нөхцөл, болзлын дагуу Зээлдэгчид зээл олгохыг зөвшөөрсөн болно.

Тиймээс, Зээлдэгч болон Банк дараах зүйлийг харилцан тохиролцов:

I ЗҮЙЛ– НИЙТЛЭГ ЗҮЙЛ, ТОДОРХОЙЛОЛТ

1.01. Ерөнхий нөхцөл (Зээлийн хэлэлцээрийн Хавсралтад тодорхойлсон) энэхүү Зээлийн хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

1.02. Тусгайлан өөрөөр заагаагүй бол энэхүү Зээлийн хэлэлцээрт ашигласан оноосон нэр /том үсгээр эхлэн бичсэн/ томъёог Ерөнхий нөхцөл эсвэл энэ Зээлийн хэлэлцээрийн хавсралтад тусгасан утгаар ойлгоно.

II ЗҮЙЛ -ЗЭЭЛ

2.01. Банк Зээлийн хэлэлцээрийн Хуваарь 1-т тусгасан Хөтөлбөр (“Хөтөлбөр” гэх)-ийг санхүүжүүлэхэд зориулан нэг зуун сая ам.доллар (100,000,000 ам.доллар) (“Зээл” гэх) -ыг энэхүү Зээлийн хэлэлцээрт заасан нөхцөлөөр Зээлдэгчид олгохоор тохиролцов.

2.02. Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрийн Хуваарь 2-ын III хэсэгт заасны дагуу Зээлийг татан авна.



- 2.03. Зээлдэгчийн төлөх үйлчилгээний төлбөр нь зээлийн дүнгийн нэг хувийн дөрөвний нэг хувь (0.25%)-тай тэнцүү байна. Зээлдэгч үйлчилгээний төлбөрийг Хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 60 хоногийн дотор төлнө.
- 2.04. Зээлдэгчийн төлөх хөрөнгө нөөцлөн баталгаажуулсан хураамж нь жилд Зарцуулаагүй зээлийн үлдэгдлийн нэг хувийн дөрөвний нэг хувь (0.25%) -тай тэнцүү байна.
- 2.05. Зээлдэгчийн Хүүгийн хугацаа тус бүрээр төлөх хүүгийн төлбөр нь Жишиг хүү дээр Тогтмол тархалтын хувийг нэмсэнтэй тэнцүү эсхүл Ерөнхий нөхцөлийн 3.02 (г) хэсгийг харгалзан Хөрвүүлэлт хийсэн хувь байна. Дээрхээс үл хамааран Зээлийн үлдэгдэлд тооцсон аливаа дүн хугацаандаа төлөгдөөгүй бөгөөд энэ нь гуч (30) хоногийн хугацаанд үргэлжилбэл Зээлдэгч нь Хувьсах хүүгийн оронд хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй дүнд тооцсон Хугацаа хэтэрсэн хүүгийн төлбөрийг эсхүл Ерөнхий нөхцөлийн 3.02 (г) хэсгийг харгалзан Хөрвүүлэлт хийсэн хүүгийн хэмжээгээр төлбөрийг төлнө.
- 2.06. Зээлийн Хүүгийн төлбөр төлөх өдрүүд нь жил бүрийн 4 дүгээр сарын 15 болон 10 дугаар сарын 15-ны өдөр байна.
- 2.07. Зээлийн хэлэлцээрийн Хуваарь 3-т заасан дүнгээр Зээлийн үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг төлнө.

III ЗҮЙЛ - ХӨТӨЛБӨР

- 3.01. Зээлдэгч нь Хөтөлбөрийн зорилгыг биелүүлэх үүрэгтэй гэдгээ мэдэгдэнэ. Үүний тулд Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн IV зүйлд заасны дагуу Хөтөлбөрийг Сангийн яам (цаашид “Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага” гэх)-аар дамжуулан хэрэгжүүлнэ.
- 3.02. Зээлдэгч болон Банк өөрөөр тохиролцоноос бусад тохиолдолд энэхүү Зээлийн хэлэлцээрийн 3.01-т зааснаар хязгаарлахгүйгээр Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрийн Хуваарь 2-т заасны дагуу хөтөлбөрийг хэрэгжүүлж байгааг баталгаажуулна.

IV БҮЛЭГ– ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 4.01. Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь Зээлийн хэлэлцээр байгуулагдсанаас хойш ер (90) хоногийн дотор байна.

V БҮЛЭГ- ТӨЛӨӨЛӨЛ, ХАЯГ

- 5.01. Ерөнхий нөхцөлийн 9.02-т заасан зорилгоор Зээлдэгчийг төлөөлөгч нь Сангийн сайд байна.



5.02. Ерөнхий нөхцөлийн 9.01-т заасан зорилгоор Зээлдэгчийн хаяг нь:

Сангийн яам

Засгийн газрын II байр
Данзангийн гудамж 5/1
Улаанбаатар - 15160
Монгол Улс

Факс: + 976- 51-267-468

5.03.Банкны хаяг нь:

Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны төв оффис,
Азийн санхүүгийн төв, А Тауэр, No.1 Тианчен зүүн зам,
Чаоянг дүүрэг, Бээжин, 100101, БНХАУ

Факс: +86-10-8358-0002

Өмнө бичигдсэн огноонд үүгээр тохиролцов.

МОНГОЛ УЛС

Гарын үсэг _____
Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

**АЗИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
БАНК**

Гарын үсэг _____
Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

ХУВААРЬ 1

Хөтөлбөрийн тодорхойлолт

Хөтөлбөрийн үндсэн зорилго нь КОВИД-19 цар тахлын нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх эрүүл мэнд, эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулах

явдал юм. Хөтөлбөрийн хүрээнд: (а) нийгмийн хамгийн эмзэг бүлэгт чиглэсэн арга хэмжээ авах, нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдэд санхүүжилтийн хуваарилалтыг нэмэгдүүлэх; (б) бүтээмжтэй салбарууд болоод бичил, жижиг, дунд үйлдвэрийг хямралаас хамгаалах арга хэмжээ авах; (в) халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хяналтыг сайжруулах арга хэмжээ авах. Хөтөлбөрийг Бодлогын захидалд илүү нарийвчлан тусгасан болно.

ХУВААРЬ 2

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх

I хэсэг. Хэрэгжүүлэх арга хэмжээ

A. Байгууллагын зохион байгуулалт

1. Зээлдэгч нь Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагаараа дамжуулан хяналт, тайлагнал зэргийг оролцуулан Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Б. Бодлогын харилцаа

1. Зээлдэгч нь Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад тулгарч буй саад бэрхшээлийн талаар Банктай нэн даруй харилцаж тухайн саад бэрхшээлийг арилгах зохистой арга хэмжээг авна.
2. Зээлдэгч нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нөлөөлж болзошгүй бусад олон талт болон хоёр талт тусламжийн байгууллагуудтай хийсэн бодлогын хэлэлцүүлгийн талаар мэдээллээр Банкнийг хангах бөгөөд Банкнаас тухайн бодлогын талаар санал хэлэх боломжийг олгоно. Зээлдэгч нь ийм аливаа саналыг боловсруулж хэрэгжүүлэхийн өмнө Банкны байр суурийг харгалзан үзнэ.

В. Харгалзах сангийн ашиглалт

1. Зээлдэгч нь Харгалзах санг Хөтөлбөрийн зорилгод нийцсэн хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийг санхүүжүүлэхийг баталгаажуулна.

Г. Хориглосон үйл ажиллагаа

1. Зээлдэгч нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцож буй боловсон хүчин болон бусад төлөөлөгчид хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад ёс зүйн



дээд түвшинг баримтлахыг баталгаажуулна. Үүний тулд Зээлдэгч нь: (а) эдгээр хүн бүрээс Зээлтэй холбогдуулан Хориглосон ямар нэг үйл ажиллагаа эрхлэхгүй байхыг шаардах; (б) Хөтөлбөрийг Хориглох үйл ажиллагааны талаар бодлогын заалтын дагуу хэрэгжүүлж байгаа эсэхийг баталгаажуулах.

II хэсэг. Хөтөлбөрийн хяналт, тайлагнал болон үнэлгээ

1. Зээлдэгч нь Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан (а) зорилтот түвшинд хүрсэн үр дүн түүний дотор жендэрийн үзүүлэлтийг хүйсээр ангилан тогтмол хугацаанд цуглуулсан мэдээлэлд үндэслэн хяналт тавьж, үнэлэх, (б) Хаалтын өдрөөс хойш 6 сарын хугацаа өнгөртөл Банканд тайланг тогтмол хүргүүлэх.
2. Зээлдэгч нь дараах чиглэлээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж Банканд мэдээлнэ: (а) макро эдийн засаг, төсвийн нөхцөл байдалд гарч буй өөрчлөлт, түүний дотор мөчлөг сөрсөн хөгжлийн төсвийн хөтөлбөр; (б) мөчлөг сөрсөн хөгжлийн төсвийн хөтөлбөрийн нийгмийн ядуу, эмзэг бүлэгт үзүүлэх үр нөлөөг хүйсээр ангилан, түүний дотор бэлэн мөнгө тараасан болон бусад нийгмийн тусламжийн хөтөлбөрүүдээс ашиг хүртэгчдийн тоо; (в) коронавирусын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах төлөвлөгөөний хэрэгжилт.
3. Энэхүү II хэсгийн 1, 2-т заасны дагуу гаргаж өгөх мэдээлэл, тайлангийн хүрээнд Зээлдэгч нь Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан Банкныг хүсэлтийн дагуу дараах мэдээллээр хангана: (а) Харгалзах сан болон түүний ашиглалт; (б) Хөтөлбөрийн хэрэгжилт, түүний дотор зорилтот түвшинд хүрсэн байдал, Бодлогын захидалд тусгасан арга хэмжээний хэрэгжилт.
4. Ерөнхий нөхцөлийн 4.08 (в) хэсэгт заасан зорилгын дагуу Төгсгөлийн тайланг Хаалтын өдрөөс хойш зургаан сарын дотор Банканд гаргаж өгнө.

III хэсэг. Зээлийн эх үүсвэрийг татан авах

A. Ерөнхий

1. Зээлдэгч нь Зээлийн эх үүсвэрийг Ерөнхий нөхцөлийн II зүйл, энэ хэсэгт заасны дагуу болон Банкнаас Зээлдэгчид мэдэгдсэн бусад нэмэлт зааварчилгааны дагуу татан авч ашиглана.

Б. Татан авах нөхцөл болон хугацаа

1. Энэ Хэсгийн А–д заасныг үл харгалзан Банк үйлчилгээний шимтгэлийг бүрэн хүлээн авах хүртэл Зээлийн данснаас мөнгө шилжүүлэхгүй.
2. Зээлийн дүнгийн хуваарилалт. Зээлийг нэг удаагийн шилжүүлгээр гүйцэтгэх бөгөөд түүнээс хойш Зээлдэгч нь Зээлийн данснаас гүйлгээнүүд хийж болно. Энэ зорилгоор зээлийн дүнгийн хуваарилалтыг тогтоосныг дор хүснэгтээр үзүүлэв.

Хуваарилалт	Хуваарилагдсан зээлийн дүн (Ам.доллараар илэрхийлэгдсэн)
Нэг удаагийн шилжүүлэг	100,000,000
НИЙТ ДҮН	100,000,000

3. Зээлийн дүнг шилжүүлэх. Банк өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд:
 - (а) Зээлийн данснаас гарсан бүх мөнгийг Банк нь Зээлдэгчийн тодорхойлсон, Банк хүлээн зөвшөөрсөн Орлогын дансруу шилжүүлнэ;
 - (б) Зээлдэгч нь Зээлийн дүнг Зээлийн данснаас Орлогын дансанд байршуулсан тохиолдол бүр түүнтэй тэнцэх хэмжээний дүнг Зээлдэгчийн төсвийн удирдлагын системд Банканд хүлээн зөвшөөрсөн байдлаар тооцохыг баталгаажуулна.
4. Энэхүү Хуваарь 2-ын Хавсралт 1-д заасан аливаа зүйлийг санхүүжүүлэх зорилгоор зээлийн эх үүсвэрээс шилжүүлэг хийхгүй.
5. Ерөнхий нөхцөлийн 2.04 (в) хэсэгт болон Ерөнхий нөхцөлийн Хавсралтын 8-д заасны дагуу Хаалтын өдөр нь 2021 оны 6-р сарын 30-ны өдөр байна.

В. Санхүүгийн тайлан, аудит

1. Зээлдэгч нь Банканд хүлээн зөвшөөрөгдөх нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу Орлогын дансны бүртгэлийг тусгах зорилгоор тусад нь данс, бүртгэлийг хөтөлнө.
2. Зээлдэгч нь Банкны хүсэлтийн дагуу Орлогын дансны санхүүгийн тайлан («Санхүүгийн тайлан») -г Банканд тогтмол мөрдөж буй аудитын стандартын дагуу мэргэшсэн, туршлагатай, ажлын тодорхойлолт нь



Банкаар хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн аудитаар шалгуулна. Зээлдэгч нь Санхүүгийн тайлан, аудиторуудын санал дүгнэлтийг англи хэл дээр бэлэн болсон даруй, ямар ч тохиолдолд Банк хүсэлт гаргаснаас зургаан (6) сарын дотор Банканд хүргүүлнэ.

IV хэсэг. Бусад зүйл

1. Зээлдэгч нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зээлийн эх үүсвэрээс гадна шаардагдах хөрөнгө, байгууламж, үйлчилгээ болон бусад эх үүсвэрийг нэн даруй бэлэн болгоно.

Хуваарь 2-ын Хавсралт 1

Хориотой жагсаалт

Зээлийн эх үүсвэрийг дараах зүйлд зарцуулж үл болно. Үүнд:

- (i) Банкнаас Зээлдэгчид мэдэгдсэний дагуу Нэгдсэн Үндэсний Байгууллагын Олон улсын худалдааны стандарт ангиллын Хувилбар 3 (ОУХСА, Хувь.3) –т заасан дараах бүлгүүд эсвэл дэд бүлгүүд эсвэл ОУХСА-ын цаашдын шинэчилсэн найруулгын дагуу шинээр тогтоож болох бүлгүүд эсвэл дэд бүлгүүдэд багтсан бараа бүтээгдэхүүний зардал.

Хүснэгт: Хориотой зүйлс

Бүлэг	Толгой дугаар	Зүйлийн тодорхойлолт
112		Архи согтууруулах ундаа
121		Тамхи, үйлдвэрлэгдээгүй; тамхины дайвар бүтээгдэхүүн
122		Тамхи, үйлдвэрлэгдсэн (тамхи орлуулагч агуулсан эсэхээс үл хамааран)
525		Цацраг идэвхт болон холбогдох түүхий эд
667		Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, өнгөлсөн болон өнгөлөөгүй
718	718.7	Цөмийн реакторууд, тэдгээрийн хэсэг, түлшний элементүүд (түүнийг агуулсан сав), задраагүй цөмийн реакторууд
728	728.43	Тамхи боловсруулах тоног төхөөрөмж



897	897.3	Алт, мөнгө болон платинум ангиллын металл (цаг болон цагны хайрцгаас бусад) болон алт, мөнгөний дархны эдлэл (үнэт гоёлыг оролцуулан)
971		Алт, мөнгөн бус (Алтны хүдэр, баяжмалаас бусад)

Эх сурвалж: Нэгдсэн Үндэсний Байгууллага

- (ii) Зээлдэгчийн валютаар болон зээлдэгчийн нутаг дэвсгэрээс нийлүүлсэн барааны зардал;
- (iii) Банкны зээл, тусламжаар санхүүжсэн аливаа гэрээг оролцуулан аливаа үндэсний болон олон улсын санхүүгийн байгууллага, агентлаг санхүүжүүлсэн эсвэл санхүүжүүлэхээр тохиролцсон гэрээний дагуу нийлүүлэгдсэн бараа материалын зардал;
- (iv) Цэргийн болон хагас цэргийн зориулалттай эсвэл тансаг хэрэглээнд зориулагдсан бараа бүтээгдэхүүний зардал;
- (v) Мансууруулах бодисын зардал;
- (vi) Зээлдэгчийн хууль тогтоомж эсвэл Зээлдэгчийн оролцогч олон улсын гэрээнд заасны дагуу үйлдвэрлэх, ашиглах, импортлохыг хориглосон байгаль орчинд аюултай бараа бүтээгдэхүүний зардал; болон
- (vii) Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн VII бүлэгт заасны дагуу НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн дагуу Зээлдэгч хориглосон аливаа зардал.

ХУВААРЬ 3

Эргэн төлөлтийн хуваарь

1. Дараах хүснэгтэд Зээлийн Үндсэн төлбөр төлөх өдөр тус бүрээр төлөгдөх Зээлийн үндсэн дүнд эзлэх хувийг харуулав («Үндсэн төлбөр төлөлтийн хувь»). Зээлийн эх үүсвэрийг Үндсэн төлбөр төлөх өдрийн байдлаар зээлийн эх үүсвэрийг бүрэн татан авсан бол Зээлдэгч Үндсэн төлбөрийн төлөх өдөр тус бүр төлөх зээлийн үндсэн дүнг Банк дараах үржвэрээр тодорхойлно. (а) Зээлийн үндсэн төлбөрийн анхны өдөр хүртэл авсан зээлийн дүн; (б) Үндсэн төлбөр төлөх өдөр тус бүрт харгалзах Үндсэн төлбөр төлөлтийн хувь.



Үндсэн төлбөр төлөх өдөр	Үндсэн төлбөр төлөлтийн хувь (Хувиар илэрхийлэв)
4 дүгээр сарын 15, 10 дугаар сарын 15-ны өдөр бүр 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 2035 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл	3.85%
2036 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр	3.75%

2. Хэрэв Зээлийн эх үүсвэрийг анхны Үндсэн төлбөр төлөх өдрөөс өмнө бүрэн татаж аваагүй бол Зээлдэгч Үндсэн төлбөр төлөх өдөр тус бүрээр төлөгдөх зээлийн үндсэн дүнг дараах байдлаар тодорхойлно.
- (а) Анхны үндсэн төлбөр төлөх өдрийн байдлаар Зээлийн эх үүсвэрээс татан авсан тохиолдолд Зээлдэгч нь Энэхүү Хуваарийн 1-т заасны дагуу тухайн өдрүүдэд Зээлийн татан авсан дүнгээс эргэн төлнө.
- (б) Зээлийн Үндсэн төлбөр төлөх анхны өдрөөс хойш татан авсан зээлийг тухайн зээлийн татан авалт хийгдсэн өдрөөс хойш Үндсэн төлбөр төлөх өдрүүдэд Банкнаас тооцоолсон дүнгээр эргэн төлнө. Банк эргэн төлөлтийн дүнг тодорхойлохдоо тухайн татан авсан зээлийн дүн тус бүрийг бутархай тоогоор үржүүлэн тооцоолох бөгөөд уг бутархайн хүртвэр нь энэхүү Хуваарийн 1-т заасан хүснэгтэд тодорхойлсон Үндсэн төлбөр төлөх өдөрт харгалзах анх тохирсон үндсэн төлбөр төлөлтийн эх хувь («Үндсэн төлбөр төлөлтийн эх хувь»)-тай тэнцүү, хуваарь нь тухайн өдөр болон түүнээс хойших Үндсэн төлбөр төлөх өдрүүдэд харгалзах бүх Үндсэн төлбөр төлөлтийн эх хувийн нийлбэртэй тэнцүү байна.
3. (а) Зөвхөн аль нэг Үндсэн төлбөр төлөх өдөр төлөх дүнг тооцоолох зорилгоор Үндсэн төлбөр төлөх өдрөөс өмнөх хоёр (2) сарын дотор татан авсан зээлийн хэмжээг тухайн зээл татан авсан өдрийн дараах буюу хоёр дахь Үндсэн төлбөр төлөх өдөр гэхэд татан авалт хийгдээд байгаа бөгөөд төлөгдөөгүй байгаа зээл гэж үзэх ба татан авалт хийгдсэний дараах хоёр дахь Үндсэн төлбөр төлөх өдрөөс эхлэн Үндсэн төлбөр төлөх өдөр бүр уг зээлийн эргэн төлөлтийг хийнэ.
- (б) Энэ зүйлийн (а) дэд хэсгийн заалтуудыг үл харгалзан, Хэрэв Банк Үндсэн төлбөр төлөх өдөр болон эсвэл дараа

нь нэхэмжлэл гаргах төлбөрийн нэхэмжлэлийн хугацаатай системийг нэвтрүүлбэл тус систем нэвтэрсэн өдрөөс хойш гарсан аливаа татан авалтад тус дэд хэсгийн заалтууд үйлчлэхгүй.

ХАВСРАЛТ

Хэсэг I. Тодорхойлолтууд

1. “Зээлдэгч” гэдэг нь Ерөнхий нөхцөлд тодорхойлсон Хүлээн авагч гэсэн тодорхойлолт.
2. “Харгалзах сан” гэдэг нь Хөтөлбөрт хамрагдах зээлийн эх үүсвэрээс бий болсон дотоодын мөнгөн тэмдэгт.
3. “Орлогын данс” гэдэг нь Хуваарь 2-ийн III хэсгийн Б.3-т заасны дагуу Банкны зөвшөөрөл бүхий Зээлийн данснаас зээлийг татан авах данс.
4. “Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага” гэдэг нь Зээлийн хэлэлцээрийн 3.01-т заасан утга.
5. “Ерөнхий нөхцөл” гэдэг нь 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн “Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны Засгийн газарт олгох зээлийн талаар Ерөнхий нөхцөл”.
6. “Бодлогын захидал” гэдэг нь Зээлийн хэлэлцээрийн оршлын (А)-д заасан хөгжлийн бодлогын захидал.
7. “Хориглох үйл ажиллагааны бодлого” гэдэг нь Банкны 2016 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн “Хориглох үйл ажиллагааны талаар бодлого”.

Хэсэг II. Ерөнхий нөхцөлд өөрөөр ойлгох өөрчлөлтүүд

Ерөнхий нөхцөлд дараах өөрчлөлтүүд хийгдсэн:

1. Ерөнхий нөхцөлд заасан «Төсөл» гэсэн нэр томъёог «Хөтөлбөр» гэсэн нэр томъёогоор орлуулах.
2. Ерөнхий нөхцөлд заасан «Төсөл хэрэгжүүлэгч байгууллага» гэсэн нэр томъёог «Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага» нэр томъёогоор орлуулах.
3. 4.01 Хэсэгт заасан Ерөнхий төслийн хэрэгжилт-ийг дараах байдлаар ойлгоно. Үүнд: “Хэсэг 4.01. Ерөнхий хөтөлбөрийн хэрэгжилт. Зээлдэгч



нь Хөтөлбөрийг дараах байдлаар хэрэгжүүлнэ: (i) Захиргаа, санхүү, төрийн бодлого, нийгэм, засаглалын нягт, үр дүнтэй туршлагад нийцүүлнэ; (ii) Хууль эрх зүйн хэлэлцээрүүдэд нийцүүлнэ.”

4. Хэсэг 4.09 Санхүүгийн удирдлага; Санхүүгийн тайлангууд; Аудитууд гэсэн хэсгийг хассан.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1,5

Индекс: 200003